

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**
/2023 оны жилийн эцэс/

2024 оны 02 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Улсын бүртгэлийн ерөнхий газарт ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажиллагаа холбогдох хууль, дүрэм, журмын дагуу явагдаж буй эсэхийг шалгаж, ажлын үр дүнг тооцох, цаашид анхаарах асуудлаа тодорхойлж, ажлыг сайжруулах талаар санал, зөвлөмж өгч, дэмжлэг, үзүүлэх зорилгоор уг үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж гүйцэтгэв.

УБЕГ-ын өргөдөл, гомдлыг хүлээн авах хэлбэр:


Иргэн хуулийн этгээдээс өргөдөл, гомдлыг Засгийн газрын <https://zasag.mn> цахим хуудасны 11-11 мэдээллийн төв, УБЕГ-ын фэйсбүүк хаяг, Бүртгэлийн нэгдсэн лавлах утас 1800-1890, бичгээр зэрэг бүх төрлийн хэлбэрээр хүлээн авч байна.

Хүлээн авсан өргөдөл, гомдол:

Тайлангийн хугацаанд Улсын бүртгэлийн байгууллагад иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол санал хүсэлт талархал 6700 үүнээс IV улиралд 1085 өргөдөл гомдол санал хүсэлт талархал байна. Хүлээн авсан хэлбэрээр харуулбал:

Д/д	Өргөдөл гомдол хүлээн авсан хэлбэр	Жилийн эцэс өссөн дүн	Эзлэх хувь
1	Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн	595	8.9
2	Байгууллагын тусгай дугаараар (1800-1890)	72	1.1
3	Вэб сайт, аппликэйшн, сошиал флатформ, мэйл	6	0.1
4	11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн	1739	26
5	ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн	4288	64
Нийт		6700	100

Хүлээн авсан өргөдөл гомдлыг төрөл: графикаар харуулбал:



Улсын бүртгэлийн байгууллагад 2023 онд ирүүлсэн нийт өргөдөл гомдлын 66%-ийг хүсэлт , 25%-ийг гомдол, 8%-ийг талархал , 1%-ийг санал эзэлж байна.

Өргөдөл гомдлын агуулгыг хүснэгтээр харуулбал:

Д/д	Гомдлын агуулга	Гомдол	Санал хүсэлт талархал	Нийт	Хувь
1	Иргэний бүртгэлийн үндсэн үйл ажиллагаа	897	2,304	3,201	47.8
2	Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үндсэн үйл ажиллагаа	236	197	433	6.5
3	Хуулийн этгээдийн бүртгэлийн үндсэн үйл ажиллагаа	146	289	435	6.5
4	Бүртгэл, хяналтын үндсэн үйл ажиллагаа	161	1,008	1,169	17.4
5	Хүний нөөцийн чиглэлээр	77	549	626	9.3
6	Албан хаагчийн ёс зүйн асуудлаар	114	2	116	1.7
7	Улсын бүртгэлийн нэгдсэн архив	11	145	156	2.3
8	Бусад	68	496	564	8.4
	НИЙТ	1,710	4,990	6,700	100


Дээрхээс үзэхэд ирүүлсэн гомдлын 47.8 хувийг Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаа (*төрөлт, нас баралт, нөхөн бүртгэл, лавлагаа, хуулбар, гэрчилгээ, гадаад паспорт авах, гэр бүлийн бүртгэл, цахим үнэмлэх, шилжилт хөдөлгөөн*), 17.4 хувийг Бүртгэл, хяналтын үндсэн үйл ажиллагаа (*зөрчил арилгуулах, хүчингүй болгох, шалгуулах, хориг цуцлуулах, залруулах, дүгнэлт гаргуулах*), 9.3 хувийг Хүний нөөцийн чиглэлээр (*ажилд орох, шилжин ажиллах, сургалт, чөлөө хүсэх, ажлаас чөлөөлөгдөх, орон сууц хүсэх, бусад*) -тай холбоотой хандалтууд байна.

Шийдвэрлэж хариу өгсөн байдал		Жилийн эцэс өссөн дүгээр	
Шийдвэрлэж хариу өгсөн	Албан бичгээр	4121	6221
	Цахимаар	5	
	Утсаар	1928	
	Биечлэн	167	
Бусад байгууллага д шилжүүлсэн	Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо	7	9
	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо	2	
Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/		1	1
Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/		-	-
Хугацаа болоогүй		469	469
Шийдвэрлэх боломжгүй		-	-
Нийт		6700	

Иргэн, хуулийн этгээдээс 6,700 өргөдөл, гомдол, санал, хүсэлт, талархал ирүүлсний 6,221 /91,3%/ -ийг шийдвэрлэснээс 4,121 /66%/ албан бичгээр 1,928 /31%/

утсаар шийдвэрлэн хариу өгсөн байна. Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 1 өргөдөл гомдол байна.


Бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890 лавлах нь 4 оператортайгаар ажиллаж байгаа бөгөөд тус лавлах утсанд IV улиралд 25,086 дуудлагад хариу өгсөн.



Бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890 лавлах утсанд ирсэн нийт дуудлагыг нэгжээр нь ангилан үзэхэд ИУБГ-44%, ЭХЭУБГ-13%, ХЭУБГ-16% -ийг тус тус эзэлж байгаа ба бүртгэлийн үйл ажиллагаатай (ИБГ-төрсний бүртгэл, овог солих, гэрлэлтийн бүртгэл, нас баралтын бүртгэл, регистрийн дугаар засуулах, нэрийн үсгийн алдаа засуулах, үрчлэлтийн бүртгэл, цахим гадаад паспорт, цахим үнэмлэх, шилжилт

хөдөлгөөний бүртгэл, хуулийн этгээдийг шинээр бүртгүүлэх, хэлбэр өөрчлөх, салбар бүртгүүлэх, загвар маягт татах, бичиг баримтын зөрчил арилгуулах, баримт бичиг ашигласан тухай, хориг цуцлах, хүүхдийн мөнгө олголттой холбоотой эд хөрөнгө эрхийн улсын бүртгэлийн лавлагаа мэдээлэл г.м) холбоотой дуудлагууд зонхилж байна.

Хүлээн авч, зөвлөгөө мэдээлэл өгсөн дуудлагын тоог улирлаар харуулбал:



2023 онд 1800-1890 лавлах утсанд өссөн дүнгээр нийт 94,068 дуудлага ирснээс I улиралд 23,177 (24.6%), II улиралд 22,068 (23.5%), III улиралд 23,737 (25.2%), IV улиралд 25,086 (26.7%) дуудлага хүлээн авч хариу өгсөн байна.